

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ 08 ДУГААР САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 09 дүгээр сарын 04

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад холбогдох заалтуудын 2023 оны 08 дугаар сарын хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 зорилтын хүрээнд 1 арга хэмжээний хэрэгжилтийг хамруулсан болно. Үүнд:

1.Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно” зорилтод тусгагдсан “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.

Хэрэгжилт: “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системийн туршилтыг үе шаттайгаар хийж, 08 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн виз, визийн зөвшөөрлийн хүсэлтүүдийг хүлээн авч, шийдвэрлэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад хамаарах арга хэмжээний хэрэгжилт 08 дугаар сард 70 хувьтай үнэлэгдлээ.

Дээрх арга хэмжээний хүрээнд “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системийн үйл ажиллагаа жилийн эцэст хэвийн явагддаг болсон байх зорилт тавьсан тул уг арга хэмжээний удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗАР